

UCS 1402B:2022

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах
усан оргилуурт тавих ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт
тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 23-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	6
2. Норматив эшлэл.....	6
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	7
4. Нийтийн эзэмшлийн талбайд байршуулах усан оргилуурын ерөнхий шаардлага.....	7
5. Усан оргилуурын ангилал	8
6. Төлөвлөлтийн шаардлага.....	9
7. Байршил сонгох.....	11
8. Хийц, бүтээцийн шаардлага	12
9. Материал, тоног төхөөрөмжийн шаардлага.....	12
10. Цорго	13
11. Насос станц ба дамжуулах холбох хэрэгсэл.....	14
12. Хөвөгч хавхалга, усан дээрх гадаргуугийн хог хаягдал зайлуулагч	15
13. Усны түвшин мэдрэгч хэрэгсэл.....	16
14. Усан сан /ус хадгалах сав/	16
15. Холигч, ус шүүгч төхөөрөмж.....	17
16. Нэгдсэн хяналт зохицуулалтын удирдлагын автомат систем.....	18
17. Цахилгаан тоног төхөөрөмж, хяналтын систем	19
18. Усан оргилуурын мэдээллийн сан, цахим бүртгэл.....	20
19. Хамгаалалт	21
20. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ.....	23
21. Усан оргилуурыг хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	25
Хавсралт 1. Нийтийн эзэмшлийн олон үйлдэлт усан оргилуурын жишиг загвар	26
Хавсралт 2. Олон үйлдэлт усан оргилуурын жишиг загвар.....	27
Хавсралт 3. Олон үйлдэлт тавцантай усан оргилуурын суурилалт	28
Ашигласан материалын жагсаалт	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Интерактив буюу Олон үйлдэлт усан оргилуур (Жишээ зураг)	8
Зураг 2. Чимэглэлийн усан оргилуур (Жишээ зураг)	8
Зураг 3. Усан толио (Жишээ зураг)	8
Зураг 4. Тавцант усан оргилуур (Жишээ зураг).....	8
Зураг 5. Усан хөшиг бүхий усан оргилуур (Жишээ зураг).....	8
Зураг 6. Тоглоомын талбай бүхий усан оргилуур (Жишээ зураг).....	8
Зураг 7. Хөшөө дурсгал уран баримал бүхий (Жишээ зураг).....	9
Зураг 8. Усан сан бүхий (Жишээ зураг).....	9
Зураг 9. Усан оргилуурыг байрлуулах зай хэмжээ (Жишээ зураг).....	10
Зураг 10. Усан оргилуурын төлөвлөлтийн бүрдэл (Жишээ зураг)	10
Зураг 11. Усан сангийн гүн /хэмжээ/ (Жишээ зураг).....	11
Зураг 12. Усан оргилуурын бүрдэл хэсэг (Жишээ зураг)	13

Зураг 21. Ус сорох хоолой (Жишээ зураг)	14
Зураг 23. Ус дамжуулах насос (Жишээ зураг)	14
Зураг 25. Ус хаах хоолой (Жишээ зураг)	15
Зураг 27. Хөвөгч хавхалга (Жишээ зураг)	15
Зураг 28. Хажуу тал нүүр тал (Жишээ зураг)	15
Зураг 29. Хог хаягдал сорогч төхөөрөмж (Жишээ зураг)	16
Зураг 30. Хажуу тал нүүр тал (Жишээ зураг)	16
Зураг 31. Усны түвшин мэдрэгч (Жишээ зураг)	16
Зураг 32. Хажуу тал нүүр тал (Жишээ зураг)	16
Зураг 42. Ерөнхий схем (Жишээ зураг).....	18
Зураг 44. Ерөнхий схем (Жишээ зураг).....	18
Зураг 45. Цахилгаан тоног төхөөрөмж (Жишээ зураг).....	19
Зураг 50. Аюулгүй ажиллагааны мэдээллийн самбар (Жишээ зураг)	21
Зураг 51. Аюулгүй ажиллагааны тэмдэг (Жишээ зураг)	22
Зураг 52. Яаралтай үед хэрэглэх галын дохиолол хэрэгсэл (Жишээ зураг)	22
Зураг 53. Хэт халалтын үед хэрэглэх нарны хэт ягаан туяа болон орчны бохирдлоос хамгаалах хэрэгсэл (Жишээ зураг)	23
Зураг 54. Өвлийн улиралд усан оргилуурыг хамгаалж орчны аюулгүй байдлыг хангах (Жишээ зураг).....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийтийн эзэмшлийн газарт ашиглах зориулалттай усан оргилуур хэмжээ (Жишээ).....	11
Хүснэгт 2. Усан оргилуурын усан сан хэмжээс (Жишээ)	11
Хүснэгт 3. Хүснэгт 3. Цоргоны төрөл	13
Хүснэгт 4. Дамжуулах хоолой насос станцын төрөл	14
Хүснэгт 5. Хөвөгч хавхалга, усан дээрх гадаргуугийн хог хаягдал зайлуулагчийн төрөл..	15
Хүснэгт 6. Усны түвшин мэдрэгч хэрэгсэл.....	16
Хүснэгт 7. Усан сан ус хадгалах савны төрөл.....	16
Хүснэгт 8. Ус шүүгч, холигч төхөөрөмжийн төрөл	17
Хүснэгт 9. Нэгдсэн хяналт, зохицуулалтын автомат системийн төрөл	18
Хүснэгт 10. Гэрэлтүүлгийн төрөл ангилал	20
Хүснэгт 11. Усан оргилуурын ашиглалтын байдлын мэдээллийн сан	21
Хүснэгт 12. Усан оргилуурын байдалд хяналт, үнэлгээ хийх чиглэл	24
Хүснэгт 13. Усан оргилуурыг хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	25



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

┌ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө ┐
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг
- 1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт
- 1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1116100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 23
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

UCS 1402B:2022 “НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД БАЙГУУЛАХ УСАН ОРГИЛУУРТ ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурыг шинээр төлөвлөх, барьж байгуулах, байрлуулах, засварлах, үйл ажиллагаанд мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангах ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

MNS 6043:2019. Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага;

- БНБД 30-01-04 - Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 21-01-02 - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- БНБД 21-04-05 - Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- БНБД 3,0106-90 - Барилгын орчны тохижилтын ажил;
- БНБД 31-03-03 - Олон нийт иргэний барилга;
- БНБД 40-02-16 - Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж;
- БНБД 40-01-14 - Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж;
- БНБД 40-05-16 - Барилга байгууламжийн доторх ус хангамж, ариутгах татуурга;
- MNS 5973:2009 - Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин;
- MNS 4586:1998 - Усны орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага;
- MNS 4943:2000 - Усны чанар. Хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 899-92 - Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх бүлгийг сонгох; журам ба эрүүл ахуйн шаардлага.
- MNS 6182:2010 Усан бассейн, чийрэгжүүлэлтийн усан санд тавих ерөнхий шаардлага
- MNS 4025:1987 Усан сангийн угсармал төмөр бетон эдлэл. Ерөнхий техникийн шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Төвлөрсөн ус хангамжийн систем - гэж усны эх үүсвэр, ус боловсруулалт, ус дамжуулах хоолой, ус түгээгүүрийн сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах байгууламж;

Ус хангамжийн схем - гэж усны эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх ус хангамжийн системийн нэгжүүдийн харилцан хамаарах байршил;

Ус боловсруулалт - гэж аливаа усыг хэрэглэгч, хүлээн авагчийн шаардлагад нийцүүлэх зориулалтын тоног төхөөрөмж, байгууламжийн ажиллагаа;

Ус татамжийн барилга - гэж усны эх үүсвэрээс ус авах зориулалттай барилга;

Ус дамжуулах барилга - гэж усны нэг цэгээс нөгөөд шилжүүлэх үүрэгтэй барилга байгууламж.

4. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД БАЙРШУУЛАХ УСАН ОРГИЛУУРЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, тохижилтын талбайд байрлуулсан усан оргилуур нь эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, хотын бичил уур амьсгалыг чийгшүүлэх ач холбогдолтой нийтийн эзэмшлийн эд хөрөнгө юм.

4.1. Усан оргилуурыг олон нийтийн орон зайн төлөвлөлт, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, талбай, үйлчилгээний төвүүдтэй уялдуулан төлөвлөж зураг төслийн дагуу барьж байгуулна.

4.2. Нийтийн эзэмшлийн талбайд байршуулах усан оргилуур нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

4.2.1. Усны хэрэглээний эдийн засгийн үр ашигтай холбоотой стандарт шаардлагуудыг зураг төсөлд тусгах;

4.2.2. Усан оргилуурын ойр орчмыг ая тухтай, аюулгүй байхаар тохижуулах;

4.2.3. Хот, тосгоны нутаг дэвсгэр дэх усан оргилуур нь нэгдсэн төвийн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон, усны эрүүл ахуйн стандартыг хангасан байх бөгөөд бие даасан инженерийн шугам сүлжээнд холбох тохиолдолд батлагдсан ажлын зургийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэх;

4.2.4. Усан оргилуурын байгууламжийн материал хийц эдлэл нь бат бөх, засварлахад хялбар, цаг агаарын эрс тэс нөхцөлд тохирсон, байгаль болон хүнд ээлтэй байх;

4.2.5. Усан оргилуурын цахилгааны эд ангийг гаднын нөлөөллөөс хамгаалж стандартын шаардлага хангасан ус, чийг болон халуун, хүйтнээс хамгаалсан төхөөрөмжөөр тоноглох;

4.2.6. Усан оргилуурын материалын эдэлгээг уртасгах зорилгоор энэхүү баримт бичигт заасан хугацаанд байнгын үзлэг хийж засварлах;

4.2.7. Усан оргилуурын дэргэд ашиглалттай холбоотой заалтуудыг ойлгомжтой бичсэн самбарыг холбогдох стандарт, шаардлагын дагуу байрлуулна. Мөн гэнэтийн осол аваар болон гал унтраах үед хэрэглэгдэх зааварчилгаа болон бүдүүвч зургийг байрлуулсан байх;


4.2.8. Суурьшлын бүсэд байрлах усан оргилуурын усны түвшин нь түүний хүчин чадал, ус оргилох өндрөөс шалтгаалж 40-65 см хэмжээтэй байна.

5. УСАН ОРГИЛУУРЫН АНГИЛАЛ

Усан оргилуурын хамрах хүрээ болон зориулалтаар нь 2 ангилна. Үүнд:



Зураг 1.Интерактив буюу Олон үйлдэлт усан оргилуур
(Жишээ зураг)



Зураг 2.Чимэглэлийн усан оргилуур (Жишээ зураг)

5.1. Интерактив буюу олон үйлдэлт усан оргилуур

Хүмүүс интерактив усан оргилууртай харьцаж, усанд тоглодог тул олон үйлдэлт усан оргилуурууд нь гоёл чимэглэлийн усан оргилууруудаас эрс ялгаатай байдаг. Тиймээс интерактив усан оргилуур нь олон нийтийн эрүүл мэндийг дэмжих үүднээс усыг эргэлтэд оруулах, цэвэрлэх зориулалттай байна

5.1.1. Олон үйлдэлт усан оргилуур нь тухайн орчны агаарыг чийгшүүлэх, хүн амрах, сэрүүцэх, хоорондоо харилцах, хүүхэд багачууд тоглох боломж бүхий байгууламж юм.




Зураг 3.Усан толио
(Жишээ зураг)



Зураг 4.Тавцант усан оргилуур
(Жишээ зураг)




Зураг 5.Усан хөшиг бүхий усан оргилуур (Жишээ зураг)



Зураг 6.Тоглоомын талбай бүхий усан оргилуур (Жишээ зураг)

5.2. Чимэглэлийн усан оргилуур

Чимэглэлийн усан оргилуур нь тухайн орчны агаарыг чийгшүүлэх, иргэдэд ая тухтай орчинд амрах, усны чимээг сонсох боломжийг бүрдүүлнэ.




Зураг 7. Хөшөө дурсгал уран баримал бүхий
(Жишээ зураг)

Зураг 8. Усан сан бүхий
(Жишээ зураг)

6. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА

Шинээр байгуулах, одоо байгаа усан оргилуурыг дахин засварлан сайжруулахдаа тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, байршил, онцлог, хэрэгцээний судалгаанд тулгуурлан холбогдох хууль, норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөнө. Үүнд:

- 6.1. усны зарцуулалт, чанар, нөөцийн хэмжээ, хангамж, түрэлтийн онцлогтой уялдуулан ус хангамжийн систем, схемийн төлөвлөлтийн төрлийг сонгох;
- 6.2. хөрс, гадаргуугийн болон төсвийн тооцоонд үндэслэн батлагдсан ажлын зургийн дагуу барилгын ажил эхлүүлэх;
- 6.3. усан сан бүхий усан оргилуурын дэргэд ногоон байгууламж тохижилтын элемент төлөвлөхдөө аль болох навчит ургамлаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь модноос навч унах нь ашиглалтын зардлыг зохиомлоор нэмэгдүүлдэг ба навчнууд нь ус зайлуулах хоолой, шүүлтүүр, цорго зэрэгт орж бөглөрдөг. Үүнээс гадна ургамлын навчны органик нэгдэл нь усны чанарт сөргөөр нөлөөлдөг;
- 6.4. усан оргилуурын бүрдэл болох тоног төхөөрөмжид навч, мөчир, чулуу гэх мэт зүйлс орж гэмтээх, хэвийн ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй тул мод, ургамал, хайрга, байгалийн чулуу зэрэг ландшафт тохижилтын үндсэн элементүүдийг усан оргилуураас 10 метрээс ойр зайд төлөвлөхгүй /зураг 9/.



Зураг 9. Усан оргилуурыг байрлуулах зай хэмжээ (Жишээ зураг)



Зураг 10. Усан оргилуурын төлөвлөлтийн бүрдэл (Жишээ зураг)

- 6.5. Усан оргилуурын бүх хэсэгт ариутгалын бодисыг жигд тараахын тулд орц, гарцыг усны жигд эргэлтэд оруулахаар төлөвлөнө.
- 6.6. Усыг налуу ашиглан зайлуулан шавхах тохиолдолд 400м² хүртэл талбайтай, 38 тн буюу түүнээс дээш усны багтаамжтай төлөвлөх үед нэг орох цорго төлөвлөнө.
- 6.7. Усан оргилуурын усан сангийн гүний стандарт: Усан оргилуурын усан сангийн гүн нь усан оргилуурын гадаад орчны зориулалт болон оргилж буй усны цацралтын түвшний өндрөөс хамаарч харилцан адилгүй байна.
 - 6.7.1. Зочид буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдааны төв, оффис, орон сууц гэх мэт нийтийн эзэмшлийн газарт ашиглах зориулалттай усан оргилуур нь дараах хэмжээтэй байна.

*Хүснэгт 1. Нийтийн эзэмшлийн газарт ашиглах зориулалттай
усан оргилуур хэмжээ (Жишээ)*

Д/д	Усны цацралтын дээд түвшин (м)	Усан сангийн усны гүний хэмжээ (см)
1	2.2 м	40-50 см
2	3 м	40-50 см
3	3.5 м	40-50 см
4	4 м	40-50 см
5	5 м	45-50 см
6	6 м	50-60 см


6.7.2. Тасралтгүй ажиллагаатай (өдөр, шөнө) ,өөр өөр түвшний өндрөөс шүршдэг, цагаригийн хэмжээс 2 ба түүнээс дээш том хэмжээний усан оргилуурын усан сан нь дараах хэмжээтэй байна.

Хүснэгт 2. Усан оргилуурын усан сан хэмжээс (Жишээ)

Д/д	Усны цацралтын дээд түвшин (м)	Усан сангийн усны гүний хэмжээ (см)
1	2.75 м	50-60 см
2	3.75 м	50-60 см
3	4.75 м	50-60 см
4	6 м	55-60 см
5	6 м-ээс дээш	60-65 см

Эх сурвалж: The Big Book Of Fountains by Fontana /United kingdom/

Анхаарах шаардлагатай: Усан оргилуурын тэмдэг тэмдэглэгээ хэсэгт тухайн усан сангийн гүний хэмжээг байршуулсан байх шаардлагатай.



Зураг 11. Усан сангийн гүн /хэмжээ/ (Жишээ зураг)

- 6.8. Сургууль, цэцэрлэгийн ойролцоо байрлах усан оргилуур нь усан сан руу ойртох, унахаас сэргийлсэн хаалт, хашлагатай байх ба түүнийг архитектурын хийц ашиглан төлөвлөнө.
- 6.9. Усан оргилуурын усыг налуу ашиглан шавхах үед урсгалын хурд 1 секундэд 70 см-ээс ихгүй байна.
- 6.10. Ус түгээлтийг нэгэн зэрэг тасалдуулахаас сэргийлж гадаргын нэг эх үүсвэрийн 2 байрлалд ус татах байгууламж ашиглахыг зөвшөөрнө.

7. БАЙРШИЛ СОНГОХ

Цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуурын байршлыг зөв сонгох нь хамгийн чухал бөгөөд зураг төслийг боловсруулах явцад анхаарах чухал элемент юм.

- 7.1. Олон үйлдэлт усан оргилуурыг төлөвлөхдөө хот суурины хүн ам, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн дагуу байршлыг тогтооно.
- 7.2. Чимэглэлийн усан оргилуурын байгууламжийг дангаар нь төлөвлөх үед байршлыг сонгохдоо тохижилтын бүрдэл болох сандал, хогийн сав, гэрэлтүүлэг, явган зам багтаахаар тооцно.
- 7.3. Улирлын чанартай үйл ажиллагаагаа явуулдаг цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуурын ойролцоо нийтийн бие засах газар байхгүй бол нийтийн хэрэгцээнд зориулж ариун цэврийн түр байгууламж байгуулах шаардлагатай.

8. ХИЙЦ, БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА

Усан оргилуурын ус хангамжийн далд шугам сүлжээ болон өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж, хэрэгслийг суурилуулах, түүнчлэн ус хангамжийн барилга, байгууламж дотор шугам хоолойг угсрахын тулд ажлын байрны хэмжээг тодорхойлохдоо БНБД 4006-02-/Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж/ дагуу гүйцэтгэнэ.


- 8.1. Барилгын газрын доорх хэсэг ба эзлэхүүний байгууламжийг суурилуулахдаа ачаалал, үйлчлэл, хэт ачааллын коэффициент, түүний нөлөөллийг БНБД 2.01.0790, БНБД 40-06-02-/Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж/ дагуу гүйцэтгэнэ.
- 8.2. Усан оргилуурын цахилгааны тоног төхөөрөмжийг суурилуулахдаа БНБД 40-0612, БНБД 40-06-12-ын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал болон орчны аюулгүй байдлыг хангана.
- 8.3. Усан оргилуурын усыг дүүргэх, тодорхой түвшинд тогтоох, ус бага үед төхөөрөмжийг аваарын горимд шилжүүлэн унтраах, усны чанарыг тодорхойлох төхөөрөмж, салхи болон хүйтний мэдрэгчийг европын болон ISO стандарт хангасан баталгаажуулалттай хяналтын нэгдсэн системээр тоноглоно.
- 8.4. Усан оргилуурын байгууламжийн бүрдэл хэсгүүдийг холбож угсрахад хялбар, эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад саадгүй байршилд байрлуулах хэрэгтэй.
- 8.5. Бүрэн автоматжуулсан нэгдсэн удирдлагын системийг гэнэтийн осол аваарын үед механик горимд шилжихээр тоноглоно.

9. МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШААРДЛАГА

9.1. Усан оргилуур нь дараах үндсэн бүрдэл хэсгүүдтэй байх бөгөөд тус бүрд хэрэглэх материал, тоноглолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд;

- даралтат насос, шугам сүлжээ хоолойнууд
- цорго;
- ус хадгалах сав;
- шүүлтүүр;
- цахилгаан, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, систем;
- нэгдсэн автомат, механик технологи бүхий систем;
- суурийн байгууламж;
- усны түвшин мэдрэгч;
- ашиглалт, арчлалтын бүртгэлийн систем;
- нийтийн ундны цэвэр ус уух байгууламж.

- 9.2. Усан оргилуурын бүтээцийн материал нь бат бөх байх бөгөөд бетоны марк В20/ М100-с бууруулахгүй байх шаардлагатай. Ажлыг гүйцэтгэхдээ холбогдох стандарт, норм ба дүрмийн дагуу гүйцэтгэнэ.
- 9.3. Суурийн хийц дээр усанд тэсвэртэй, халтиргаагүй, үйлдвэрийн аргаар боловсруулсан байгалийн чулуун өнгөлгөөний хавтан хэрэглэж болно.
- 9.4. Ханын хэсэгт дүүргэгч материал болон тоосго хэрэглэж болно.
- 9.5. Усан оргилуурын дотор хэсэгт усанд тэсвэртэй гипсэн зуурмагийг багадаа 2 үе хийх ба эпокси/ резин, давирхайт/ будгаар мөн 2 үе будна.




Зураг 12. Усан оргилуурын бүрдэл хэсэг (Жишээ зураг)

10. ЦОРГО

- 10.1 Цоргыг усны хамгаалалттай, үйлдвэрийн аргаар хүрэл болон сайжруулсан металлээр бүрсэн материалаар гүйцэтгэсэн байх шаардлагатай.
- 10.2. Салхины нөлөөллийн эсэргүүцэл сайн гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 3. Цоргоны төрөл


Гейзер цорго	Баримал бүхий цорго	Цацраг цорго	Хөшиг бүхий цорго
			
Зураг 13. (Жишээ зураг)	Зураг 14. (Жишээ зураг)	Зураг 15. (Жишээ зураг)	Зураг 16. (Жишээ зураг)




11. НАСОС СТАНЦ БА ДАМЖУУЛАХ ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ

- 11.1. Ус соруулах, буцах шугам хоолойг усанд тэсвэртэй сайжруулсан металл болон зэсээр бүрсэн материалаар хийнэ. Байрлалаас нь хамааруулан хэвтээ, босоо гэж ангилна.
- 11.2. Холбох хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг олон улсын стандарт хангасан усанд тэсвэртэй сайжруулсан хуванцар хоолойгоор хийж болно.
- 11.3. Ган болон хуванцар, төмөр бетон хоолойг тооцооны үндэслэлээр дамжуулах хоолойд хэрэглэж болно.

Хүснэгт 4. Дамжуулах хоолой насос станцын төрөл





Зураг 25. Ус хаах хоолой
(Жишээ зураг)


Зураг 26. (Жишээ зураг)

- 11.4. Насосын төхөөрөмжийн хийцийн онцлог чадал ба хүчдэлийн тооцоо, насос станцын төлөвлөлтийг харгалзан дамжуулах хоолойн төрлийг сонгоно.
- 11.5. Насос станцын хаалт нээх, хаах, ус дүүргэх, тоног төхөөрөмжийг хөргөх зэрэг туслах бүх үйлдлүүдийг автоматаар гүйцэтгэхээр төлөвлөнө.

12. ХӨВӨГЧ ХАВХАЛГА, УСАН ДЭЭРХ ГАДАРГУУГИЙН ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАГЧ


- 12.1. Усан оргилуурын усыг аюулгүй, халихгүй түвшинд тогтвортой байлгах зорилго бүхий хөвөгч хавхалга суурилуулна. Усыг усан сангийн байгууламжаас халин гарахаас хамгаална.
- 12.2. Усан дээрх гадаргуугийн хог хаягдлыг зайлуулах хоолой нь усны гадарга дээр хөвж буй хуванцар болон хөнгөн хог хаягдлыг цуглуулах үүрэгтэй бөгөөд хуримтлагдсан хог хаягдлыг ашиглагч этгээд цэвэрлэхэд хялбар зохион байгуулалттай байх шаардлагатай.
- 12.3. Хөвөгч хавхалга, хог хаягдал зайлуулагч төхөөрөмжүүд нь ус зайлуулах шугамд шууд холбогдсон байх шаардлагатай.

Хүснэгт 5. Хөвөгч хавхалга, усан дээрх гадаргуугийн хог хаягдал зайлуулагчийн төрөл




Зураг 27. Хөвөгч хавхалга
(Жишээ зураг)

Зураг 28. Хажуу тал Нүүр тал (Жишээ зураг)



Зураг 29.Хог хаягдал сорогч төхөөрөмж (Жишээ зураг)



Зураг 30.Хажуу тал Нүүр тал (Жишээ зураг)

13. УСНЫ ТҮВШИН МЭДРЭГЧ ХЭРЭГСЭЛ


13.1. Усны түвшнийг тодорхой түвшинд хадгалах зориулалт бүхий мэдрэгч хөвүүрийг усан санд байрлуулна. Усан сангийн усны түвшинд тохируулан сонгох бөгөөд 36 см-ээс ихгүй усан сантай оргилуурт хэрэглэнэ.

13.2. Хөвүүр нь усанд тэсвэртэй, хөнгөн хуванцар материалаар гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 6.Усны түвшин мэдрэгч хэрэгсэл



Зураг 31.Усны түвшин мэдрэгч (Жишээ зураг)









Зураг 32.Хажуу тал Нүүр тал (Жишээ зураг)

14. УСАН САН /УС ХАДГАЛАХ САВ/

14.1. Тухайн усан оргилуурын хүчин чадлаас хамааруулан олон улсын стандартыг хангасан сайжруулан нягтруулсан полиэтилен, металл, хуванцар материал хэрэглэж болно. Ус хадгалах савны багтаамж тухайн усан сангийн хүчин чадлаас хамаарна.

14.2. Ус хадгалах савыг хөрсөнд суурилуулахдаа хавсралт 1-д заасны дагуу гүйцэтгэнэ.






Хүснэгт 7. Усан сан ус хадгалах савны төрөл

 <p>Зураг 33. (Жишээ зураг)</p>	<p>Хажуу тал</p>  <p>Нүүр тал</p>  <p>Зураг 34. (Жишээ зураг)</p>
 <p>Зураг 35. (Жишээ зураг)</p>	  <p>Зураг 36. (Жишээ зураг)</p>

15. ХОЛИГЧ, УС ШҮҮГЧ ТӨХӨӨРӨМЖ

15.1. Холигч нь ус цэвэрлэгээний технологийн ажиллагааг түргэтгэх үүднээс ус ба ус цэвэршүүлэх урвалжийг сайн холилдуулахаар хийцтэй байна.

Хүснэгт 8. Ус шүүгч, холигч төхөөрөмжийн төрөл





 <p>Зураг 37. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 38. (Жишээ зураг)</p>
 <p>Зураг 39. (Жишээ зураг)</p>	  <p>Зураг 40. (Жишээ зураг)</p>

- 15.2. Холигч нь дамжуулах хоолой ба сувагт усны байх хугацааг харгалзан урвалжийг хийх хугацааны дарааллыг хангах ёстой. БНБД 40-06-02 /Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж/
- 15.3. Бактерицидийн төхөөрөмжийн тоог тухайн төхөөрөмжийн паспортод заасан бүтээмжээр тодорхойлно. Ажлын төхөөрөмжийн тоог үйлдвэрлэгчийн зааврын дагуу авна.
- 15.4. Янз бүрийн зориулалттай насос станцыг байнгын ажилтангүйгээр автоматаар удирдахаар төлөвлөнө.

16. НЭГДСЭН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН АВТОМАТ СИСТЕМ

- 16.1. Усан оргилуурын усыг дүүргэх, тодорхой түвшинд тогтоох, ус бага үед төхөөрөмжийг аваарын горимд шилжүүлэн унтраах, усны чанарыг тодорхойлох төхөөрөмж, салхи болон хүйтний мэдрэгчийг европын болон олон улсын (ISO) стандарт хангасан баталгаажуулалттай хяналтын нэгдсэн системээр тоноглоно.
- 16.2. Усан оргилуурын гэрэлтүүлгийн гэрлийн тусгал, гэрлийн тод, бүдгийн тохиргоо, даралт болон цацруулалтын өндрийг нэгдсэн зохион байгуулалтаар хангасан хяналтын систем суурилуулсан байна.
- 16.3. Автомат удирдлагын системийн үйл ажиллагаа нь ажиллаж байгаа насос станцуудын тусламжтайгаар хамгийн бага зардлаар хэрэгцээт усны хэмжээг хангах, усны алдагдлыг хэмнэлттэй доод хэмжээнд хүртэл бууруулах, үргүй зардал ба шүүрэлтээр алдагдах усны хэмжээг багасгах үүрэгтэй.


Хүснэгт 9.Нэгдсэн хяналт, зохицуулалтын автомат системийн төрөл

 <p style="text-align: center;">Зураг 41. (Жишээ зураг)</p>	 <p style="text-align: center;">Зураг 42.Ерөнхий схем (Жишээ зураг)</p>
 <p style="text-align: center;">Зураг 43. (Жишээ зураг)</p>	 <p style="text-align: center;">Зураг 44.Ерөнхий схем (Жишээ зураг)</p>

- 16.4. Автоматжуулалтын схем нь удирдлагын команд ирэх үед насосын төхөөрөмжийг залгах, технологийн болон цахилгааны хамгаалалт ажилласан үед насосыг аваарын салгалт хийх нөхцөлийг хангасан байна.
- 16.5. Насос станц доторх насосын агрегат бүрийн даралттай ус дамжуулах хоолой дээр даралт ба зарцуулалт, түүнчлэн дренажын ус цуглуулах нүх ба вакум тогоон дахь усны түвшин, шаардлагатай бол агрегатуудын холхивчийн температур, усанд авталтын аваарын түвшин зэргийг өдөр тутам хэмжиж байх шаардлагатай.
- 16.6. Зураг төслийг гүйцэтгэхдээ тухайн байгууламжийн автоматжуулалтын, технологийн процессын диаграммыг боловсруулна.
- 16.7. Процессын диаграммд бүх тоног төхөөрөмж, байгууламжууд, хэмжүүрийн тоноглолуудын гаргах өгөгдөл, тоног төхөөрөмжийн удирдах өгөгдлүүдийг дүрслэн, мөн урсгалын чигийг үзүүлсэн байх бөгөөд төхөөрөмжийн дэргэд хүний нүдэнд тод харагдахуйц хэмжээтэй, байрлалд байрлуулна.

17. ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХЯНАЛТЫН СИСТЕМ

- 17.1. Ус хангамжийн байгууламжийн автоматжуулалтын системийг бүтээмж, ажлын горим, найдвартай ажиллагаа, тавих шаардлага, ашиглагчийн ажлыг хөнгөвчлөх, ажиллах нөхцөлийг сайжруулах, эрчим хүчний хэрэглээ, ус ба урвалжийн зарцуулалтыг бууруулах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах шаардлагын дагуу төлөвлөнө.
- 17.2. Автомат удирдлагын системийн зураг төсөл зохиохдоо ус хангамжийн системийн технологийн бүх хэсгүүдийг хамруулна.
- 17.3. Цахилгаан хангамжийн байгууллагаас тавих шаардлага, нэмэгдэл тэжээлийн үүсвэрийг суурилуулах байршил, түүний чадал ба хүчдэлийг сонгосон техник эдийн засгийн үндэслэл зэргийг үндэслэн төлөвлөлтийг хийнэ.



Зураг 45. Цахилгаан тоног төхөөрөмж (Жишээ зураг)

- 17.4. Хуваарилах төхөөрөмжүүд, трансформаторын дэд станцууд, удирдлагын самбар зэргийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ба өргөтгөх боломжтойгоор барилга дотор байрлуулна.
- 17.5. Байгууламжийн автоматжуулалтын зэрэглэлд нийцүүлэн сонгон авсан өгөгдлүүд, түүний ашиглалтын нөхцөл ба эрүүл ахуй-халдвар судлалын албанаас усны чанар, бүрэлдэхүүнд тавьсан шаардлага зэргийг үндэслэн хяналтын үзүүлэлтүүдийг тодорхойлно.
- 17.6. Галын дохиолол, гал унтраах системийг БНБД21-04-05-д заасны дагуу угсарна.
- 17.7. Ус хангамжийн байгууламжийн цахилгаан хангамжийн найдваржилтын категори нь “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД 43-101-03-ээр тодорхойлогдоно.
- 17.8. Цахилгаан хөдөлгүүрийн хүчдэл, хийц, загварыг сонгохдоо объектын хэтийн төлөвлөлтэй уялдуулан түүний хүчин чадал, цахилгаан тэжээлийн батлагдсан схем, суурилуулах өрөөний орчин нөхцөлийг харгалзан үзнэ.

- 17.9. Усан доорх гэрэл болон бусад цахилгааны тоноглолууд нь усны хамгаалалттай материалаар хийгдсэн, цахилгааны бүрэн автомат тохиргоотой байх шаардлагатай.
- 17.10. Усан доорх цорго болон гэрэлтүүлэг нь олон улсын стандартыг хангасан, усанд тэсвэртэй, металл хийцтэй их бие бүхий, нягтруулан сайжруулсан шилэн гадаргуутай, лед гэрэлтэй, тодорхой төрлийн цоргонууд байна.
- 17.11. Чийглэг болон хуурай нөхцөлд байрлуулах үед олон улсын стандарт хангасан, цаг агаарын хүнд нөхцөлд тэсвэртэй ус, чийгийн хамгаалалт, лед гэрэлтэй, байрлалаа чөлөөтэй өөрчилж хөдлөх боломжтой, засварын сэлбэг материал түгээмэл олдоцтой байна.
- 17.12. Гэрэлтүүлэгтэй холбогдох холболтын тоног төхөөрөмж, цахилгааны утас, тоноглол нь олон улсын чанарын стандартыг хангасан хүрэл, сайжруулсан металл, усанд тэсвэртэй материалаар хийгдсэн байх шаардлагатай.
- 17.13. Цахилгааны тоног төхөөрөмжүүд нь 15 Вольт-оос доош хүчин чадалтай бол заавал шилжүүлэгч хэрэглэнэ.
- 17.14. Гэрэлтүүлгийг тухайн усан оргилуурын архитектурын шийдэл, төрлөөс хамааруулан усан доторх, чийглэг, хуурай газар байрлуулж болно.

Хүснэгт 10. Гэрэлтүүлгийн төрөл ангилал

<p>Усан дотор, чийглэг, хуурай хэсэгт байрлуулах үед</p>  <p><i>Зураг 46. (Жишээ зураг)</i></p>	<p>Гэрэлтүүлэг, цорго хамт тоноглогсон үед</p>  <p><i>Зураг 47. (Жишээ зураг)</i></p>
 <p><i>Зураг 48. (Жишээ зураг)</i></p>	 <p><i>Зураг 49. (Жишээ зураг)</i></p>

18. УСАН ОРГИЛУУРЫН МЭДЭЭЛЛИЙН САН, ЦАХИМ БҮРТГЭЛ

- 18.1. Баригдаж ашиглалтад орсон усан оргилуур бүрийн мэдээлэл хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд орж жил бүр дараах мэдээллээр баяжилт хийгдэнэ. / Хүснэгт 9/

Хүснэгт 11. Усан оргилуурын ашиглалтын байдлын мэдээллийн сан

Анхдагч мэдээлэл	Баяжих мэдээлэл
<ul style="list-style-type: none"> - Байршил - Эзэмшигч - Төрөл, хүчин чадал - Гүйцэтгэгч - Тоног төхөөрөмж, материалын мэдээлэл - Баталгаат хугацаа 	<ul style="list-style-type: none"> - Засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл - Ашиглалтын явцад гарсан гэмтэл, доголдол - Эзэмшигч өөрчлөгдсөн тэмдэглэл

- 18.2 Яаралтай үед холбогдох албан тушаалтны холбоо барих утасны дугаарыг тэмдэглэнэ.
- 18.3 Гэнэтийн осол аваар болон гал унтраах үед хэрэглэгдэх зааварчилгаа болон бүдүүвч зургийг байрлуулсан байх.
- 18.4 Усан оргилуурын байгууламжийн ил гарсан хэсэгт хурц ирмэг, газрын түвшнээс доош болон ус зайлуулах суваг дээрх том нүх, халтиргаа үүсгэх гадаргуу, ил гарсан цахилгааны утас, том хэмжээний хатуу хог хаягдал болон бусад аюултай зүйлсийг байрлуулахыг хориглоно.



Зураг 50. Аюулгүй ажиллагааны мэдээллийн самбар (Жишээ зураг)

Тухайн усан оргилуурын ерөнхий схем зураг /QR/ код дараах мэдээллийг багтаасан байна.

Тухайн усан оргилуурын байгуулагдсан он, хүчин чадал, цагийн хуваарь, олон нийтэд зориулагдсан хөтөлбөр, хориглох зүйлс, холбогдолтой зураг зэрэг орно.

19. ХАМГААЛАЛТ

- 19.1. Засвар, үйлчилгээний ажил урт хугацаагаар явагдах үед олон нийтэд усан оргилуурыг түр хугацаагаар хаах засварын ажил үргэлжлэх, дуусах хугацааг, яаралтай үед холбогдох ажилтны утасны дугаарыг мэдээллийн самбарт байршуулна.
- 19.2. Усан оргилуурын цахилгааны хяналтын самбар болон тоног төхөөрөмжийн өрөөнд гадны хүн нэвтрэхийг хориглосон тэмдгийг зураг 15-д заасны дагуу байрлуулах бөгөөд өрөөний хаалгыг сайн чанарын бат бөх металлаар хийсэн байна.



Зураг 51. Аюулгүй ажиллагааны тэмдэг (Жишээ зураг)

- 19.3. Гэмтлээс урьдчилан сэргийлэхийн тулд усан оргилуурыг шөнийн цагаар унтраах нь зүйтэй. Тухайн усан оргилуурын байршил, төрлөөс хамааруулан шөнийн 22.00 цагаас хойш ажиллуулах тохиолдолд ашиглагч байгууллага нь холбогдох байгууллагаас зөвшөөрөл авна.
- 19.4. Газрын түвшнээс доош орсон нүх зэргийг битүүлэх тагласан байна.
- 19.5. Шаардлагатай тохиолдолд бага насны хүүхэд болон гаднын хүн орохоос сэргийлсэн хамгаалалтын болон түр хашааг байрлуулж болно.
- 19.6. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно. (Галын аюулгүй байдлын тухай хууль 19.3)



Зураг 52. Яаралтай үед хэрэглэх галын дохиолол хэрэгсэл (Жишээ зураг)

- 19.7. Хүйтний улиралд гадна орчны температур 00 С /цельс/ болохоос өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Үүнд: /Зураг 17/

- усан оргилуурын цахилгааны аюулгүй байдлыг сайтар шалгаж, усан сан, ус хадгалах сав болон бүх тоног төхөөрөмж дэх усыг бүрэн шавхах;
- ил гарсан цорго болон гэрэлтүүлгийг цаг уурын эрс тэс уур амьсгал, -40°C -ийн градуст тэсвэртэй бат бөх материалаар хийсэн уутаар бүтэн битүүмжлэх.



Зураг 53.Хэт халалтын үед хэрэглэх нарны хэт ягаан туяа болон орчны бохирдлоос хамгаалах хэрэгсэл (Жишээ зураг)



Зураг 54.Өвлийн улиралд усан оргилуурыг хамгаалж орчны аюулгүй байдлыг хангах (Жишээ зураг)

19.8. Усан оргилуурын шилэн хийц болон өндрийн уналт, халтиргаа үүсэж болзошгүй архитектурын шийдэл бүхий элементүүдийг зориулалтын зураг 18-ын дагуу цаг уурын эрс тэрс уур амьсгал, -40°C -ийн градуст тэсвэртэй бат бөх материалаар хийгдсэн уутаар бүтэн битүүмжилнэ.

20. ЦЭВЭРЛЭГЭЭ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

20.1. Нийтийн эзэмшлийн усан оргилуурын бүртгэл хөтлөх, цэвэрлэгээ, засвар, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын систем” нэвтрүүлж цогцоор нь зохион байгуулах байгуулна.



Зураг 55.Засвар үйлчилгээний хэрэгсэл (Жишээ зураг)

Хүснэгт 12.Усан оргилуурын байдалд хяналт, үнэлгээ хийх чиглэл

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдол / мөөгөнцөр, хуванцар сав, навч бохирдол/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Усан оргилуурын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Хагарсан, эмтэрсэн гадаргын бүтээц эдлэлийн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Цахилгааны ил задгай хамгаалалтгүй утас унжсан, ил гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Автомат нэгдсэн удирдлагын системийн бүрэн доголдолгүй ажиллагаа хэвийн байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн усан оргилуур нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

21. УСАН ОРГИЛУУРЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нийтийн эзэмшлийн усан оргилуурын төлөвлөлт, материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг Усан оргилуурыг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 11.) -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 13. Усан оргилуурыг хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Усан оргилуурын ажлын зураг батлагдаж магадлалын дүгнэлт гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Усан оргилуурыг батлагдсан зураг төслийн дагуу бүрэн бэхэлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Усан оргилуурыг нэгдсэн инженерийн шугам сүлжээнд холбосон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Усан оргилуурын бүрдэл бүрэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Усан оргилуурыг стандартын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Усан оргилуурын техник тоног төхөөрөмжүүдийн материал чанар стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Усан оргилуурын материал хийц эдлэлд ус, байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Усан оргилуурын тавцангийн чулуун хийц хэсгүүд халтиргаагүй, стандартын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Усан оргилуурын төлөвлөлтийг түүний төрөлд тохируулан төлөвлөсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Усан оргилуурын усны чанарын шинжилгээ стандартад нийцсэн эсэх холбогдох магадлал хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Усан оргилуурын загвар нь тухайн орчны эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэх Монгол улсын цаг агаарын нөхцөлд тохирох эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Усан оргилуурын ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага оновчтой бүрэн хийгдэж, зөв байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн усан оргилуур нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ОЛОН ҮЙЛДЭЛТ УСАН ОРГИЛУУРЫН ЖИШИГ ЗАГВАР




Зураг 56. (Жишээ зураг)



Зураг 57. (Жишээ зураг)

ХАВСРАЛТ 2.

ОЛОН ҮЙЛДЭЛТ УСАН ОРГИЛУУРЫН ЖИШИГ ЗАГВАР



Зураг 58. (Жишээ зураг)

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 30-01-04 - Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- БНБД 21-01-02 - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал
- БНБД 21-04-05 - Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл
- БНБД 3,0106-90 - Барилгын орчны тохижилтын ажил
- БНБД 31-03-03 - Олон нийт иргэний барилга
- БНБД 40-02-16 - Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж
- БНБД 40-01-14 - Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж
- БНБД 40-05-16 - Барилга байгууламжийн доторх ус хангамж, ариутгах татуурга
- MNS 973:2009 - Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин
- MNS 4586-1998 - Усны орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
- MNS 4943-2000 - Усны чанар. Хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 899-92 - Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
- City of Portland, Oregon, Design guidelines for Interactive Fountains
- http://www.femyers.com/products/sse/sse_mec200.html
- https://fluidra-engineering.com/wp-content/uploads/2018/04/FOUNTAINS-SOLUTION_ENG_2018_compressed.pdf
- Fountain People catalog, United states of America
- <http://www.saferain.com/en/>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар